

## **НОХОЙ, МУУР ТЭЖЭЭХ, ҮРЖҮҮЛЭХ, ХУДАЛДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү журмаар эзэнтэй нохой, муурыг бүртгэлжүүлэх, хүн, мал, амьтныг нохой мууранд хазуулах болон нохой муурнаас үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үржлийг хянах, нохой, муур өмчлөгчийн хариуцлагыг зохицуулах, нохой муурны албан татварыг төвлөрүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журмыг Монгол улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаад, дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд **нийтээр** дагаж мөрдөнө.

### **Хоёр. Нэр томъёоны тайлбар**

2.1 “Эзэнтэй нохой, муур” гэж харьяа нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид бүртгэлтэй, олон нийтийн газар, гэр, хашаандаа хараа хяналттай байгаа нохой муурыг:

2.2 “Золбин нохой, муур” гэж гудамж, олон нийтийн газар зохих хамгаалалт, хараа хяналтгүй байгаа нохой, муурыг:

2.3 “Нохой, муурны тэмдэг” гэж нохой, муурны бүртгэлийн дугаартай таних тэмдэг бүхий хүзүүвч, зүүлт, цахим мэдээлэл бүхий тэмдэг /чип/, чихний ээмгийг:

2.4 “Мал эмнэлгийн байгууллага” гэж мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага, аж ахуйн нэгжийг:

2.5 “Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага” гэж мал эмнэлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрыг хэрэгжүүлэгч агентлагийг:

2.6 “Үргүйжүүлэх ажиллагаа” гэж эр нохойг засах, эм нохойны үрийн сувгийг боох мэс ажилбарыг:

### **Гурав. Нохой, муурыг бүртгэлжүүлэх**

3.1 Эзэнтэй нохой, муур нь нохой, муурны тэмдэг, паспорттой байх ба бүртгэлийг хорооны Засаг дарга хийж, паспорт олгоно.

3.2 Шинээр бүртгүүлж, паспорттой болсон нохой, муурыг бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор тэмдэгжүүлэх ба нохой, муурны тэмдгийг хорооны Засаг даргад бүртгүүлсэн бүртгэл бүхий паспортыг үндэслэн мал эмнэлгийн байгууллага олгоно.

3.3 Нохой, муурны бүртгэлийн дугаар нь “.....” хэлбэртэй, дахин давтагдашгүй дугаарлалттай байна.

3.4 Нохой, муурны паспорт нь нохойны нэр, зураг, гарал үүсэл /удмын талаарх мэдээлэл/, өнгө зүс, үүлдэр, эзний нэр, эзний хаяг, утасны дугаар, шилжилт хөдөлгөөний мэдээлэл, нохой, муурны албан татвар төлсөн тэмдэглэл, урьдчилан сэргийлэх тарилга, үзлэгт орсон тэмдэглэл зэрэг мэдээллийг агуулсан байна.

3.5 Нохой, муур эзэмшигч нь нохой, муурыг төрснөөс хойш 1 сарын дотор бүртгүүлж, нохой, муурны тэмдэг, паспорт авна.

3.6 Нохой, муурны бүртгэл хийлгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.6.1 эзний иргэний үнэмлэх

3.6.2 гарал үүслийн бичиг

3.6.3 нохой, муурны албан татвар төлсөн баримт

3.6.3 мал эмнэлгийн байгууллагад урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээнд хамруулсан тухай баримт бичиг

3.7 Нохой, муур эзэмшигч нь эзэмшигч солигдсон, нохой, муур үхсэн тохиолдолд 30 хоногийн дотор хорооны Засаг даргад мэдэгдэж, бүртгэлээс хасуулах эсхүл бүртгэлийг шинэчлүүлнэ.

3.8 Нохой, муур алдагдсан тохиолдолд 24 цагийн дотор цагдаагийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

3.9 Баг, хорооны Засаг дарга нутаг дэвсгэрийн нохой, муурны бүртгэлийг жилд нэг удаа жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор захиргааны статистик мэдээний маягтаар өрхийн болон байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалтаар сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын статистикийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх ба сум, дүүргийн Засаг даргын тамгын газар 1 дүгээр сарын 5-ны дотор аймаг, нийслэлийн статистик тоо, мэдээлэл хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Захирагчийн Ажлын албанд хүргүүлнэ.

3.10 Эзэнтэй нохой, муурны тооллогыг жил бүрийн 12 дугаар сард аймаг, нийслэлийн статистик тоо, мэдээлэл хариуцсан төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Захирагчийн ажлын алба, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

### **Дөрөв. Хүн, мал, амьтныг нохой, мууранд хазуулах,**

#### **нохой муурнаас үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх**

4.1 Нохой, муур эзэмшигч нь дараах аюулгүйн шаардлагыг баримтална.

4.1.1. Нохой, муурыг орон сууц, гэр хорооллын хашаанд тусгайлан бэлтгэсэн байр, талбайд уяатай байлгах:

4.1.2. Хашаанд нохой, муур тэжээх тохиолдолд хашаанаас нохой, муур гарахгүй байх, гаднаас нохой, муур орохгүй байх нөхцлийг хангасан байна:

4.1.3. Нохой, муурыг нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, олон нийтийн газарт хошуувч болон уяатай байлгах:

4.1.4. Хашаанд нохой, муур тэжээх тохиолдолд “Анхаар нохойтой” тэмдэглэгээг харагдахуйц байдлаар хашааны хаалган дээр байршуулах:

4.1.5. Орон сууцанд нохой, муур тэжээх тохиолдолд оршин суугчдын аюулгүй тайван амьдрах нөхцлийг алдагдуулахгүй байх:

4.2 Нохой, муур эзэмшигч нь дараах ариун цэврийн шаардлагыг баримтална.

4.2.1 Нохой, муурны байр, хэвтэр, уяа, идүүрийг тогтмол цэвэр байлгах:

4.2.2 Нохой, муурны байр, хэвтэр, эдлэл хэрэгслийг ариутгаж, халдваргүйжүүлэх:

4.2.3 Нохой, муурыг тогтмол хугацаанд усанд оруулах:

4.2.4 Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, орон сууцны дундын өмчлөлийн явган болон цахилгаан шат, орц, хонгилыг нохой, муурны ялгадсаар бохирдуулахгүй байх ба бохирдуулсан тохиолдолд уут, саванд хийж, орчныг цэвэрлэн, зориулалтын хогийн цэгт хаях:

4.2.5 Орон сууцанд нохой, муур тэжээх тохиолдолд нохой, муурнаас үүдэлтэй бохирдол цэвэрлэхтэй холбоотой цэвэрлэгээний төлбөрийг Сууц Өмчлөгчдийн Холбоонд тухай бүр өгч байх:

4.3 Сууц Өмчлөгчдийн Холбоо нь хариуцсан орон сууцны нохой, муур эзэмшигчдээс нохой, муурнаас үүдэлтэй бохирдол цэвэрлэхтэй холбоотой цэвэрлэгээний төлбөрийг тухай бүр авч, цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийж, оршин суугчдыг цэвэр орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

4.3 Эзэнтэй нохой, муурыг жилд 1 удаа мэргэжлийн мал эмнэлгийн байгууллагаар тарилга вакцин хийлгэж, үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.

4.4 Мэргэжлийн мал эмнэлгийн байгууллага нь нохой муурнаас үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд дараах шаардлагыг баримталж ажиллана.

4.4.1 урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээ хийсэн нохой, муурны паспорт дээр тэмдэглэл үйлдэж баталгаажуулах:

4.4.2 нохой, мууранд урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээ хийсэн талаарх бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэх:

4.4.3 сар бүрийн 05-ны дотор аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагад урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээ хийсэн талаарх мэдээллийг батлагдсан маягтын дагуу хүргүүлэх ба маягыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

4.4 Нохой, муур эзэмшигч нь нохой, муур өвчилсөн тохиолдолд мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэж, эмчлүүлэх ба эмчилгээ хийлгэсэн талаарх мэдээллийг нохой, муурны паспорт дээр тэмдэглүүлнэ.

4.5 Эзэнтэй нохой, муур үхсэн тохиолдолд нохой, муурны сэг зэм устгалын байгууллагад хүлээлгэн өгч устгуулна.

4.6 Энэхүү журамд заасан үүргийг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэний талаарх мэдээллийг хорооны Засаг дарга хүлээн авч, шийдвэрлүүлнэ.

## **Тав. Нохой, муурны худалдаа, аж ахуй эрхлэх**

5.1 Байгууллага, аж ахуй нэгж, иргэн нохой, муур үржүүлж, худалдаалж, нохой, муурны мах, бусад түүхий эдийг ашиглаж, ангилж боловсруулах нохой, муурны аж ахуй эрхэлж болно.

5.2 Нохой, муур үржүүлэхтэй холбоотой аж ахуй эрхлэх эрхийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагатай “Нохой, муурны аж ахуй эрхлэх гэрээ” байгуулж олгох ба үйл ажиллагаа эрхлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагаас гэрээг цуцалж, үйл ажиллагааг зогсооно.

5.3 Нохой, муурны арьс, махыг түүхий эд болгон ашиглаж, ангилах, боловсруулах чиглэлийн аж ахуй эрхлэх эрхийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай “Нохой, муурны аж ахуй эрхэх гэрээ” байгуулсанаар олгох ба үйл ажиллагаа эрхлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд аймаг, нийслэлийн Захирагчийн ажлын албанаас гэрээг цуцалж, үйл ажиллагааг зогсооно.

5.4 “Нохой, муурны аж ахуй эрхлэх гэрээ”-г 5-аас доошгүй жилийн хугацаатай байгуулах ба жил бүр гэрээг дүгнэнэ.

5.5 Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд тавих шаардлагыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллага баталж, мөрдүүлнэ.

## **Зургаа. Нохой муурны үржлийг хязгаарлах**

6.1 Эрлийз, үүлдэр угсаа тодорхойгүй нохой, муур тэжээх тохиолдолд мал эмнэлгийн байгууллагаар үргүйжүүлэх ажиллагаа хийлгэсэн байна.

6.2 Нохой, муурыг үргүйжүүлэх ажиллагааг мэргэжлийн мал эмнэлгийн байгууллага гүйцэтгэх ба тэдний үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллага хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6.3 Мал эмнэлгийн байгууллагууд нохой, муурыг үргүйжүүлэх ажиллагааг зориулалтын багаж, техник хэрэгслээр халдвар, хамгаалал, эрүүл ахуйн шаардлага, заавар, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

6.4 Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой, муур үргүйжүүлэх ажиллагааны жишиг үнэ тарифыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллага тогтооно.

6.5 Мал эмнэлгийн байгууллагууд хийж гүйцэтгэсэн үргүйжүүлэх ажиллагааны талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагад сар бүрийн 05-ны дотор тогтоосон маягтын дагуу ирүүлэх ба маягтыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

6.6 Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн байгууллага нь аймаг, нийслэлийн Захирагчийн Ажлын албыг нохой, муурыг үргүйжүүлсэн талаарх тоо, мэдээллээр тухай бүр хангаж ажиллана.

## **Долоо. Нохойны албан татварыг төвлөрүүлэх**

7.1 Нохой эзэмшигч нь жилд нэг удаа тогтоосон хувь хэмжээгээр нохойны албан татварыг харьяа дүүргийн татварын хэлтэст төлнө.

7.2 Нохойны албан татварын хувь хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

7.2 Нохойны албан татварын орлогыг дараах үйл ажиллагаанд зарцуулна.

7.2.1 Золбин нохой, муурыг устгах:

7.2.2 Нохой, муурны сэг зэмийг устгах:

7.2.3 Золбин нохой, муурны тоог бууруулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах:

### **Найм. Бусад зүйл**

8.1. Нохой, муурны үзэсгэлэн яармаг, уралдаан, тэмцээн зохион байгуулах зөвшөөрлийг мал эмнэлгийн болон цагдаагийн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн тухайн дүүргийн Засаг даргын Тамгын газар олгоно.

8.2. Нохой, муурны үзэсгэлэн худалдаа, уралдаан, тэмцээн зохион байгуулагч нь тухай арга хэмжээний үеэр үүссэн хог хаягдлыг тухайн нутаг дэвсгэрийн хог хаягдлын үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулан цэвэрлүүлж, тээвэрлүүлэх ба гарах зардлыг бүрэн хариуцна.

8.3. Нохой, муур эзэмшигч нь хил дамжуулан нохой, муур тээвэрлэх тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журмыг баримтална.

8.4. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд нохой, муур устгалын байгууллагаас устгаснаас бусад шалтгаанаар үхсэн нохой, муурны сэг зэмийг тухайн нутаг дэвсгэрийн хог хаягдлын үйлчилгээний байгууллага ачиж, тээвэрлэн нохой, муурны сэг зэм устгах байгууллагад шилжүүлнэ.

### **Ес. Хориглох зүйл**

9.1. Эрлийз, үүлдэр угсаа тодорхойгүй нохой, муур үржүүлэхийг хориглоно.

9.2. Нохой, муурыг олон нийтийн газар хошуувч болон уяагүй авч явахыг хориглоно.

9.3. Нохой, муурыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, бусдын эдэлбэр газарт хараа хяналтгүй гаргах, сул байлгахыг хориглоно.

9.4. Нохой, муур эзэмших эрхийг урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийлгэхгүй, үзлэг шинжилгээнд оруулахгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

9.5. Урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийлгээгүй, үзлэг шинжилгээнд ороогүй, нохой, муурны тэмдэг, паспортгүй нохой, муур тэжээхийг хориглоно.

9.6. Нохой, муурыг үхсэн малын сэг зэмээр хооллохыг хориглоно.

9.7. Нохой, муураар хүн айлгах, сүрдүүлэх, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулахыг хориглоно.

9.8. Нохой, муурны албан татварыг татварын улсын байцаагчаас бусад этгээд хураахыг хориглоно.

9.9. Зориулалтын бус газар нохой, муур худалдаалахыг хориглоно.

9.10. 70 см-ээс дээш сэрвээний өндөртэй нохойг нийтийн орон сууцанд тэжээхийг хориглоно.

9.11. Нохой, муур төөрүүлж, хаяхыг хориглоно.

#### **Арав. Хариуцлага**

10.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-00000-

